300 BC – 250 AD ⁱ	Japan – Yayoi	151	161
1200-1600 ⁱ	Japan – Medieval	20	159
1603-1867 ⁱ	Japan – Edo	36	158
1450 ^g	Marianas, Taumako	70	174
1650 ^g	Easter Island	14	173
1500-1750 ^g	New Zealand	124	174
1400-1800 ^g	Hawaii	-	173

Industrious Revolution

- Эртний болон өнөөгийн анчин-цуглуулагч нийгмийн хүмүүсийн араг ясны мэдээллээс үзэхэд суурин хөдөө аж ахуйн нийгэм болон аж үйлдвэржилтийн эхлэл үеийн нийгмээс анчин-цуглуулагчийн амьдралын стандарт илүү байсан мэт харагдана.
- Амьдралын байдлыг тодорхойлох өөр нэг хэмжигдэхүүн – өдөр тутмын хүнсээ худалдаж авахад хэдэн цаг ажилладаг вэ? Ямар төрлийн хөдөлмөр эрхэлдэг вэ?

Table 3.10 Male Labor Inputs per Day⁵³

Group	Group or Activity	Hours
Tatuyo ^k	Shifting cultivation, hunting	7.6
Mikea ⁱ	Shifting cultivation, foraging	7.4
Ache ^b	Hunting	6.9
Abelam ^a	Subsistence agriculture, hunting	6.5
!Kung ^g	Foraging	6.4
Machiguenga ^h	Shifting cultivation, foraging, hunting	6.0
Xavante ^f	Shifting cultivation, hunting	5.9
Aruni ^c	Subsistence agriculture	5.2
Mekranoti ^f	Shifting cultivation, hunting, foraging	3.9
Shipibo ^j	Subsistence agriculture, fishing	3.4
Bemba ^d	Shifting cultivation, hunting	3.4
Hiwi ^e	Hunting	3.0
Yanomamo ^k	Shifting cultivation, hunting, foraging	2.8
Median		5.9
Britain, 1800 ⁿ	Farm laborers, paid labor	8.2
England, 1800 ^o	Building Workers, paid labor	9.0
London, 1800 ^p	All Workers	9.1
UK, 2000^q	All, 16-64	8.8



Industrious Revolution

- Аж үйлдвэрийн хувьсгал явагдсанаар барилгачин болон тариаланчид ажлын урт цагаар ажиллах нь хэвээр байсан.
- Тогтмол ажилтай хүмүүс жилийн 300 өдөр ажилладаг байжээ.

Table 3.11 The Work Day of English Builders⁵⁶

Decade	Towns	Hours
1720	1	10.4
1730	-	-
1740	1	8.3
1750	1	-
1760	1	11.9
1770	1	10.1
1780	2	11.3
1790	2	10.9
1800	4	10.5
1810	5	10.3
1820	7	10.3
1830	9	9.9
1840	10	9.9
1850	9	10.0
1860	8	10.0



Industrious Revolution and Welfare

- Мальтусын эдийн засгийн үед ажилчин жилд 2100 цаг ажиллаж байгаад “аж үйлдвэрийн хувьсгал” явагдаж жилийн 3200 цаг ажиллах болсон нь урт хугацаанд амьдралын сайхан байдалд хэрхэн нөлөөлөх вэ?



Industrious Revolution and Welfare

- Хөдөлмөрийн орцыг нэмэгдүүлэх нь бүтээгдэхүүний гарцыг нэмэгдүүлэх ба богино хугацаанд төрөлтийн хувь нас баралтын хувиас илүү гарч хүн ам өснө.
- Хүн амын өсөлт хангалттай явагдсаны дараа эдийн засагт шинэ тэнцвэр тогтож бодит орлого өмнөх түвшиндээ хүрэх боловч өмнө нь 2100 цаг ажиллаж авдаг байсан цалинг 3200 цаг ажиллаж авна.




Figure 2.5 The Effects of Technological Advance

Industrious Revolution and Welfare

- 1800 оны хүмүүсийн бодит амьдралын стандартыг хэмжих өөр нэг арга – хүнсний гол бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд хөдөлмөрийн нэг цагт хэчнээн килокалори үйлдвэрлэж буйг хэмжих
- Ажиллах цагаар тооцон бодит хүнсний хэрэглээ бус хэрэглээний боломжийг хэмжих арга юм.
- 1800 оны хөдөө аж ахуйн нийгэмд хөдөлмөрийн нэг цагт үйлдвэрлэх калорийн хэмжээ цуглуулагч болон байгалийн ургамал, жимс хураагч нийгмээс бага байсан.

Table 3.12 Calories produced per worker-hour, Forager and Subsistence Societies versus England, 1800.⁵⁷


Group	Location	Staple Foods	Kcal. per hour
Mikea ^f	Madagascar	Maize	110,000
Mikea ^f	Madagascar	Tuber foraging	1,770
Mekranoti ^d	Brazil	Manioc, Sweet Potato, Banana, Maize	17,600
Shipibo ^g	Peru	Banana, Maize, Beans, Manioc	7,680
Xavante ^d	Brazil	Rice/Manioc	7,100
Machiguenga ^e	Peru	Manioc	4,984
Kantu ^c	Indonesia	Dry Rice	4,500
Hiwi ^b	Venezuela	Game (men)	3,735
Hiwi ^b	Venezuela	Roots (women)	1,125
Ache ^a	Paraguay	Palm fiber, shoots (women)	2,630
Ache ^a	Paraguay	Game (men)	1,340
Foragers, median			4,740
England, 1800		Wheat, milk, meats	2,600

Conclusion

- Түүхийн олон баримт, араг ясны судалгаа Мальтусын моделийн үзэл баримтлалыг дэмжиж байна.
- 1800 оноос өмнөх амьдралын аж байдал технологийн дэвшлээс хамааралгүй байсан нийгэм бүрт өөр өөр байжээ.
- Дундад зууны үед 1348 онд Хар тахал дэгдэж хүн ам эрс цөөрч, 1550 онд хүн амын өсөлт дахин сэргэж ирэхэд Баруун Европ гайхалтай баян чинээлэг болж ирсэн.



ЛЕКЦ ДУУСАВ.




Марко Поло ба Торгоны зам



Та энэ бүлгийг судалсанаар дараах чадваруудыг эзэмшинэ:

- Дундад зууны эдийн засгийн худалдааны замын тухай тайлбарлах
- Евразийн худалдааны хотуудын тухай тайлбарлах
- 13-р зууны Монголчууд ба торгоны замын түүхийн талаар тайлбарлах
- Дэлхийн эдийн засгийн үндсэн тойрог ба далайн тээврийн хөгжлийн талаар тайлбарлах



**MARCO
POLO**
1254-1324

- 1271 онд Марко Поло аав, авга ахын хамт Венецээс Их Юань Улсыг зорьсон.
- Марко Пологийн гэр бүл Хар тэнгист Крым болон Константиноплын хооронд худалдаа хийдэг байжээ.
- Түүний аав, авга ахын хувьд хоёр дахь аялал байсан.



- Аялалын зорилго Их Хаанд Христийн сайн мэдээг хүргэх байлаа.
- Тэд Европоос азид хөл тавьсан анхны худалдаачдын хэсэг байлаа.




Марко Поло ба Торгоны зам


- Пологийнхэн Европоос дорно зүгт аялсан замын дагуу дундад зууны эдийн засгуудыг холбосон чухал зам үүссэн.
- Тухайн үед эдийн засгууд өнөөгийн дэлхийн эдийн засаг шиг нягт холбогдоогүй, тус бүрийн мөнгө, хөрөнгө оруулалтын бүтэцтэй, эд баялаг худаалдаачдын гарт төвлөрсөн байсан.



Марко Поло ба Торгоны зам

- Дундад зуунд Хятадад хамгийн баян эдийн засаг байсан.
- 16-р зуунд Европын худалдаачид шинэ газар хайж, далайгаар хайгуул хийж, эдийн засгуудыг холбохоос өмнө Марко Поло Евразийн худалдааны хотуудыг холбосон хамгийн их ашиглагддаг замаар аялсан.





- Өнөөгийн Хятадын Таджикстантай хиллэх хилийн ойролцоо Кашгар хот Торгоны замаар аялах худалдаачин, жинчидын хувьд буудаллаад өнгөрөх чухал газар байсан ба Ойрх Дорнод, Хар тэнгисийн бүс нутгийг Энэтхэг, Хятадтай холгож байв.



Марко Поло ба Торгоны зам

- Торгоны зам Евразийн олон орнуудыг дэлхийн худалдааны системд холбосон чухал зангилаа болж байв.
- Поло торгоны замын зүүн хязгаарт хүрч Их хааны эд баялагийг гайхан биширсэн тэмдэглэлүүд үлдээжээ.
- Хаанбалиг хотын худалдаа, наймааны талаар бичиж үлдээсэн.

“The multitude of inhabitants ...
is greater than the mind can comprehend.
To this city everything that is rare and valuable
in all parts of the world finds its way....
The quantity of the merchandise sold there
exceeds also the traffic of any other place.”


—Marco Polo



Марко Поло ба Торгоны зам

Өөрийн аялалыг дүрсэлсэн Марко Пологийн тэмдэглэлд худалдааны замын сүлжээг (web of trade routes) тэмдэглэн үлдээсэн

- Хятад
- Зүүн өмнөд Ази
- Энэтхэг
- Төв Ази
- Ойрх дорнод
- Европ



- 13-р зуунд Монголчууд Хятадыг эзэлж, захирч байсан үед торгоны зам өмнөх зуунуудтай харьцуулахад илүү аюулгүй болсон.
- Торгоны замын хоёр тал Хятад, Европ 1000 жилийн дараа анх удаа холбогдсон байдаг.







Марко Поло ба Торгоны зам

- Европын эдийн засгийн хөгжил Хятадын эдийн засагтай харьцуулахад маш дорой байсан.
- Технологийн хувьд Хятад маш илүү байсан. Газар тариалан, төмрийн үйлдвэрлэл зэргээр тэргүүлж байсан.
- Европын хувьд олон жижиг улсуудаас бүрдэж байсан бол Азид Монголын их гүрнүүдийн дараа бий болсон томоохон хаант улсууд байв.



- Европын худалдаачид Атлантын тэнгисээр бараа тээвэрлэж, илүү хурдан худалдаалах болсон.
- Марко Пологийн аялалаас хойш 200 жилийн дараа 1450-аад оноос эхлэн Европт улс төр, эдийн засгийн өөрчлөлт, тэлэлт явагдаж эхэлсэн.





BRASIL



Марко Поло ба Торгоны зам

- Дундад зуунаас өмнө Хятад торгоны үйлдвэрлэл эрхэлдэг цорын ганц үндэстэн байсан дэлхийн торгоны монопол байсан.
- Дундад зууны эхээр Сирийн худалдаачин торгоны хүр хорхойг Хятадаас нууцаар авч гарснаар Ойрх дорнодод мөн торгоны үйлдвэрлэлтэй болсон.





- Хятад 10-р зуунд цаасан мөнгийг анх гаргасан гэж үздэг.
- Гэтэл Европт 18-р зуун хүртэл цаасан мөнгийг нийтээр хэрэглэдэггүй байсан.



Марко Поло ба Торгоны зам

Цаасан мөнгө гарснаар,

- Мөнгөны эргэлтийн хурд нэмэгдсэн.
- Төр мөнгөны зохицуулалтыг хийх болсноор татварын орлого нэмэгдэж улсын баялаг нэмэгдсэн.



Марко Поло ба Торгоны зам

- 9-р зуунаас 14-р зууны сүүл хүртэл Хятад улсын эдийн засаг тэлэх үйл явцтай байсан.
- Хөгжлийн үндсэн суурь хөдөө аж ахуйн салбарт тулгуурласан.
- 10-р зуунд Green Revolution явагдсан. Вьетнамаас будааны шинэ сорт оруулж ирсэн.

Марко Поло ба Торгоны зам

Газар тариалан хөгжсөнөөр,

- Хүн ам өссөн.
- Хотжилт эрчимтэй явагдсан.
- Хөдөө аж ахуйгаас бусад салбар ихээр хөгжсөн.
- Далайгаар дамжин худалдаа ихээр хийх болсон.




Марко Поло ба Торгоны зам


- Хятадын усан онгоц 3000 тон (Басра, Омар боомт хүртэл аялдаг)
- Европын усан онгоц ердөө 600 тон

14-р зуунд Хятад,


- Төмрийн үйлдвэрлэл
- Экспортын бараа
- Санхүүгийн шинэчлэл (цаасан мөнгө, засгийн газрын санхүү)



- Доод Yangtze мөрөнд 15000 усан онгоц байсан тооцоо байдаг.



Марко Поло ба Торгоны зам



- Энэтхэг улсад даавууны үйлдвэрлэл асар их хөгжсөн.
- Чанарын хувьд доогуур байсан ч Зүүн Өмнөд Ази, Зүүн Африк, Ойрх дорнодод эрэлт ихтэй байсан тул зөвхөн дотоодын зах зээлээ хангахаас гадна эдгээр бүс нутаг руу экспортолдог байсан.
- Баруун өмнөд хэсгээс хар чинжүүний экспорт чухал байсан.



Марко Поло ба Торгоны зам

- Энэтхэг буудай, будааг Энэтхэг далайн бүс нутаг даяар экспортолдог байсан.
- Энэтхэгийн эдийн засаг импортоос давсан экспорттой бие даасан байжээ.
- Энэтхэгийн чухал импортын бараа Хятадын болор, Ойрх дорнодын зэс байсан.




Марко Поло ба Торгоны зам


- Энэтхэг өөрийн үйлдвэрлэлийн илүүдэл бүтээгдэхүүнтэй баян байв.
- 14-р зуун гэхэд зүүн Энэтхэгээс Хятадын өмнөд тэнгис хүртэл далайн тээвэрлэлтийг Хятадууд давамгайлан хийж байсан.
- Арабууд баруун Энэтхэгээс Ойрх Дорнод Африк хүртэл тээврийг хийдэг байсан.



Марко Поло ба Торгоны зам


- 
- Энэтхэгийн лалын шашинтай Gujarat далайн тээвэрт тодорхой байр эзэлдэг байсан.
 - Энэтхэгийн дотоодын эхэс дээдсийн тансаг хэрэглээний импортын гол бүс нутаг байсан.
 - Мөн Африкийн худалдаа, Өмнөд Энэтхэгийн транзит худалдаанд оролцдог байжээ.






VASCO DA GAMA

1460-1524






Марко Поло ба Торгоны зам

- 
- 15-р зуун гэхэд Арабын далайн тээвэр, гол боомт хотуудад хэт давамгайлж Хятадын баруун Энэтхэгтэй хийх далайн тээврийн худалдааг шахан гаргасан.
 - Хятадын цөөн хэдэн худалдаачин баруун өмнөд Энэтхэгт хүрч худалдаа хийдэг болсон.



Марко Поло ба Торгоны зам

- 
- Түүхэнд Зүүн Өмнөд Азийг Европ болон Ойрх Дорнодод эрэлт их, өндөр үнэтэй халуун ногоо нийлүүлдэг байсан гэж ихэвчлэн үздэг.
 - Европын колончлолоос өмнө Энэтхэг болон Хятад энэхүү бүс нутгийн эдийн засагт чухал байр суурь эзэлж байсан.
 - Халуун ногоо зүүн Индонезид эрэлт ихтэй байсан ба бусад бүс нутагт төдийлөн эрэлттэй байгаагүй.



Марко Поло ба Торгоны зам


- Зүүн Өмнөд Азийн эдийн засагт даавуу, хатаасан загас, давс, будаа зэрэг бараа илүү чухал байсан.
- Малакка 13-р зуун хүртэл Хятадын эдийн засгаас бүрэн хараат байсан.





Марко Поло ба Торгоны зам

- 15-р зуунд Хятад Энэтхэгтэй хийх худалдаа эрс багассанаар далайн худалдаанд эдгээр улсаас өөр улсын худалдаачид орж ирэх нөхцөл бүрдсэн.
- Ойрх Дорнод зүг бүртээ худалдаа хийх таатай байршилд байсан.





Марко Поло ба Торгоны зам

- Эдгээр худалдааны гол замууд ихээхэн өөрчлөгдсөөр байсан. Ихэнх тохиолдолд Монголчуудын байлдан дагуулалтаас болж байв.
- Дундад зууны үед Ойрх Дорнодыг дэлхийн эдийн засагт холбосон гэж үздэг.



Марко Поло ба Торгоны зам

- 13-р зуунд Монголчууд Ази, Европыг холбосон их гүрнүүдийг байгуулсны дараа дэлхийн худалдаа үнэхээр эрчимтэй хөгжиж эхэлсэн.
- Худалдааны замууд аюулгүй тайван болж ирсэн.




Марко Поло ба Торгоны зам

- Монголчууд худалдаачид байгаагүй. Үйлдвэрлэл бараг л байхгүй. Газар орноо тэлэх, эзлэн түрэмгийлэх бодлоготой байсан.
- Монголчууд алба, гувчуурт суурилсан хатуу чанд дэглэм тогтоосон.
- Яваандаа торгоны замаар жин тээвэрлэж худалдаа хийх улам эрсдэлтэй, аюултай болсон.

Марко Поло ба Торгоны зам

- Монголчууд Багдадыг эзэлснээр худалдааны хэмжээг нь эрс багасгасан.
- Персийн булангаар аялах зам Энэтхэгтэй худалдаа хийхэд ашиглагдсаар байсан.
- 13-р зуунд Европт загалмайтны улсууд унахад Италийн худалдаачид Египетээр явах замыг ихээр ашиглах болж Энэтхэгийн далайгаар явах ачааг эрс нэмэгдүүлсэн.



Марко Поло ба Торгоны зам

- Португалчууд Африкийг тойрсон замыг нээтэл энэхүү зам хамгийн тогтвортой зам байсан.
- 1291-ээс 1517 он хүртэл Европоос зүүн зүг рүү хийх худалдааны 80 хувийг Египет дангаараа хянадаг байсан.

Марко Поло ба Торгоны зам

- Египет Улаан тэнгисээр дамжин өнгөрч Энэтхэг, Хятадын баян эдийн засагтай холгох гүүр болж байсан тул Европын худалдаачдын хувьд Азид төвлөрсөн дэлхийн эдийн засагтай холбогдох гол зам байв.

POPE INNOCENT 1161-1216




Марко Поло ба Торгоны зам

- Венец худалдаан дээр тулгуурласан эдийн засагтай байсан.
- Египетын Мамлюк султаны боолын наймаа багасаж, бүс нутаг хооронд даавуу, халуун ногооны худалдааны хэмжээ эрс нэмэгдэх Европын эдийн засаг дэлхийн эдийн засагтай цааш 150 гаруй жил нягт холбогдох боломж бүрдсэн.
- Хятад, Энэтхэг, Ойрх Дорнод болон Европ гэсэн эдийн засгийн үндсэн 4 том тойрог байсан.



ЛЕКЦ ДУУСАВ.



**Хар тахлын нөлөө ба
үр дагавар**




Та энэ бүлгийг судалсанаар дараах чадваруудыг эзэмшинэ:

- Хар үхэл тахлын нийгэм, эдийн засагт үзүүлсэн нөлөөг тайлбарлах
- Хар үхэл тахлын дэгдсэн он цагийн өмнөх цаг уурын өөрчлөлтийг тайлбарлах
- Хар үхэл тахлын дэгдсэн он цагийн өмнөх Европын ургацын алдагдал эдийн засагт үзүүлсэн нөлөөний талаар тайлбарлах
- Хар үхэл тахлын дэгдсэн он цагийн өмнөх Европын Их Өлсгөлөнгийн талаар тайлбарлах
- Европ дахь 100 жилийн дайны талаар эдийн засгийн түүхийн өнцгөөс тайлбарлах



Хар Үхэл



- Бүх төрлийн өвчин, ханиад, томуу, тахал бол хүн төрөлхтний өсөлт, нийгмийн хэм хэмжээ, шашин шүтлэг зэрэгт шууд нөлөөтэй.
- Ялангуяа тахлын эдийн засагт үзүүлэх нөлөө асар их байдаг.
- Шууд нөлөө – худалдаа болон аялал жуулчлалыг хязгаарлах, эдийн засгийн бүтээмжийг бууруулах, бараа бүтээгдэхүүний эрэлт, нийлүүлэлтийг тасалдуулах
- Илүү хурцадмал байдалд хүрвэл хүн амын хямралд хүргэдэг.



Black Death

- Хар үхэл бол түүхэн дэх хамгийн аймшигт тахлуудын нэг юм.
- Дундад зууны сүүл үеийн нийгэм, эдийн засагт гүн нөлөө үзүүлсэн.



- Хар Үхэл бол 14-р зууны сүүл үед Евразийн ихэнх нутагт дэгдсэн аймшигт цар тахал юм.
- Book of Revelation of Christian Bible -
- 4 horsemen of the apocalypse – conquest, war, famine and death
- Дэлхийн сүйрлийг авчрах 4 морьтон.




Цаг уурын өөрчлөлт

- 14-р зууны сүүлээр дэлхийн цаг уур өөрчлөгдөж хүйтэн болж ирсэн ба дараах хэдэн зуунд үргэлжлэн сэрүүссэн – Little Ice Age.
- Энэхүү цаг уурын өөрчлөлт ургац хураалтад сөрөг нөлөөлж Европт их өлсгөлөн үүсэх шалтгаан болсон.
- Цаашилбал хүмүүс хүнс тэжээлийн дутагдалд орж хүнсний төлөө хоорондоо дайтаж өлсгөлөнг улам газар авхуулсан.



- Крими́йн хойг дээрх Каффа́д болсон тулаан энэхүү тахлыг Европ авчирсан байх магадлалтай.
- Энэ үед Европын хүн ам цаг уурын өөрчлөлт, дайн, өлсөгөлөнд нэрвэгдсэн байсан.

- Дундад зуун буюу ойролцоогоор 400-1400 оны эхэн үед цаг уурын дулаарал явагдсан.
- Ургацын гарцыг нэмэгдүүлэх таатай орчин бүрдсэн.
- Гэвч тухайн үеийн технологийн түвшинд гарцын хэмжээ үргэлж бага байсан.





Ургац

- Зарим жилд ургац сайтай, зарим үед ургац муу байсан ба Европт үргэлж хүнсний хомсдолтой байжээ.
- Гэхдээ хэт өлгөлөнд оролгүй хүнсний хэрэгцээ амь зуулгын түвшинд хангаж ирсэн тул 14-р зуунаас өмнө хүн ам нилээд өссөн.
- Хүн ам өссөнөөр илүү их хүнсний хэрэгцээ үүсч өмнө ашиглаж байсан газруудыг илүү ихээр ашиглах болсноор аажимдаа гарц нэмэгдсэн ч хүнсний илүүдэл гардаггүй байсан.



Цаг уурын өөрчлөлт

- 14-р зууны эхний арван жилд цаг агаар сэрүүсэж, хур тунадас ихээр орох болж хөдөө аж ахуйд хямрал нүүрлэсэн.
- 1309 онд анх баруун өмнөд Германд ургац хураалт амжилтгүй болсон. Дараа жил Европ даяар ширүүн хүйтэн бороо орсон.
- Цаг агаарын энэ үзэгдэл улам ширүүсэж 1315-1318 он хүртэл үргэжилсэн.



Ургац

- Хэт их бороо орсний улмаас 1316 он гэхэд ургацынхаа талыг авах боломжгүй болсон.
- Эдийн засгийн бүтээмжийн хувьд ургац сайтай жилд ч Европ тивийг хангахад хүрэлцэхгүй болсон.
- Цаг агаар сэрүүссэний улмаас зарим төрлийн хүнсний ногоог огт тариалах боломжгүй болсон. Жишээ: усан үзэм – Англи, Скандинав ургах боломжгүй болов.



Great Famine 1315-1317

- Жишээ: усан үзэм – Англи, Скандинавт ургах боломжгүй болов.
- Үүний улмаас 1315-1317 оны Их Өлсгөлөнгийн үе ирсэн.
- Flanders, England зэрэг газарт хүн амын 5-10% өлсгөлөнгөөр үхэв.

“The summer rains were so heavy that grain could not ripen. It could hardly be gathered and used to bake bread ... unless it was first put in vessels to dry. Around the end of autumn, the dearth was mitigated in part, but toward Christmas it became as bad as before.”

“Bread did not have its usual nourishing power and strength because the grain was not nourished by the warmth of summer sunshine. Hence those who ate it, even in large quantities, were hungry again after a little while. There can be no doubt that the poor wasted away while the rich were constantly hungry.”



Great Famine 1315-1317

- Ургацын гарц эрс муудахын зэрэгцээ зарим газруудад мал, амьтны тахал дэгдэж тоо толгойг ихээр хорогдуулсан.
- Үүний улмаас малын нийлүүлэлт эрс буурч үнэ өсөх шалтгаан болсон.
- 1322 он хүртэл Европын хөдөө аж ахуй хүн амын хүнсний хэрэгцээг хангаж чадаагүй. 1340-өөд он болтол өлсгөлөнд нэрвэгдсэн хэвээр байсан.



Great Famine 1315-1317

- Малын тахлын улмаас махны нийлүүлэлт буурч олон хүмүүс өлсгөлөнгөөр үхсээр байсан.
- Амьд үлдэгсэд нь шим тэжээлийн гүн дутагдалд орсон.
- Өлсгөлөнгийн хамгийн хүнд үед тариа, буудайны үнэ тэнгэрт хадсан (5 дахин нэмэгдсэн).



Great Famine 1315-1317

- Өлсгөлөн намжиж ирэхэд буудайны үнэ буурч эхэлсэн.
- Европын худалдаачид ялангуяа Италичууд дорноос авчирсан хямд буудайгаар Европыг хангасан.
- Ингэснээр хөдөө аж ахуйн бараа, бүтээгдэхүүн өөрчлөгдөж ирсэн.




- Дундад зууны үеийн ихэнх дайн элит язгууртнуудын цөөн цэргийн хүрээнд ихэвчлэн зун болдог байсан.
- Хүлэг баатрууд байлддаг байсан учир хүн амд нөлөө багатай байсан.



Европ дахь дайн

- Европт 1337 оноос эхлэн 15-р зууны төгсгөл хүртэл үргэжилсэн олон дайн тулаан болсон.
- 14, 15-р зуунд үргэжилсэн дайны хувьд тариалан, талбай, малын бэлчээр зэрэг бүхий л газрыг хамран тулаан хийсэн.
- Хүлэг баатар, тулаан зэрэг ажил мэргэжил болж ирсэн тул дайныг аль болох удаан үргэлжлүүлэх сонирхол их байжээ.

1346



Европ дахь дайн

- 14-р зуунд Европт ургацаа алдаж, өлсгөлөнд нэрвэгдэж, дайн тулаан, иргэний бослого газар авч хүн ам цөөрч ихээхэн хэцүү үед гэнэт тахал гарсан.
- Хүн төрөлхтөн Бурханы шүүлттэй тулгарсан мэт болсон.
- Европ тив Их Өлсгөлөнд нэрвэгдсэнээс хойш 10 жилийн дараа, 100 жилийн дайн Flanders-т үргэлжилж байхад алс хол Хятадын өмнөд хэсэгт аймшигт тахал дэгдэж байв.



Хар Үхэл

- 1330-аад онд Хятадын Хобей зэрэг зарим хотуудын хүн амын 90 хувь тахлаар үхсэн гэсэн баримт байдаг.
- 1351 он гэхэд хүн амын $\frac{2}{3}$ тахлаар үхсэн гэх тооцоо байдаг.
- Төв Азийн тал нутгийн мэрэгч амьтдын бөөсөөр дамжин халдварладаг тахал харх ихтэй Хятадын өмнөд хэсийн хотуудад ихээр тархсан.



Хар Үхэл

- Хятадууд Ази даяар болон Торгоны зам дагуу худалдаа хийхэд агуулах саванд харх үүрлэн тээвэрлэгдэж өрнийг дорнотой холбох зам дагуу тархсан.
- 14-р зууны эхээр Монголын цэрэг тахлыг анх Хятадын Хобей хотонд авчирсан байх магадлалтай.

1345

◆ Kaffa

Khanate of the
Golden Horde

1345

Hopei

Shangtung


1350-аад он

Jiangxi
Hunan

Fukien

Arabian Sea

Indian Ocean



Хар Үхэл

- Каффагаас тахал тээвэрлэгдэн Газар дундын тэнгисийн боомтууд руу очсон.
- Black Death – bubonic, pneumonic, septicemic
- Бубоник тахал хамгийн түгээмэл байсан. Халдвартай мэрэгч амьтны бөөсөнд хазуулбал өвчилдөг. Мэрэгч амьтанг үхэхээр бөөс нь үсэрч өөр бие хайдаг.




- Бубоник тахал – нууц үе 6 өдөр
- Шинж тэмдэг – хар цэврүү, булчирхайн зангирал, арьсан дотуур цус алдалт, хуралдсан цус шиг хөх ягаан толбо (Bubos) арьсан доор үүсгэдэг.
- Дотор цус алдалт мэдрэлийн системд нөлөөлдөг.

Хар Үхэл


- Бубоник тахал хамгийн хор хөнөөл багатай. Өвчлөгсөдийн 50-60 хувийг алдаг.
- Pneumonic plague – хүнээс хүнд халдварладаг. Халдвар авснаас хойш 2-3 өдрийн дараа хүний биеийн дулааныг огцом унагадаг. Хүчтэй цусаар ханиалгах, шүлсээр болон агаар дуслаар халддаг. Цөөн тохиолддог ч халдвар авагсадын 95 хувь үхдэг.
- Septicemic plague – бубоник тахал шиг бөөсөөр халдварладаг. Халдвар авснаас хойш 1 өдрийн дотор үхдэг. Бараг 100 хувь үхэлд хүргэдэг.




- Тахал мөн эх газраар харх, тэжээмэл мал амьтан, ноосон даавуу зэргээр дамжин тархаж байсан.




- Тахлын оргил үед Парист өдөрт 800 хүн тахлаар үхэж байсан.



- Дундад зууны орнуудын ижил Лондон туйлын бохир хот байсан. Тахал 2 жил үргэлжилж тус хотын хүн амын 40 хувь нас барсан.



- Скандинавын орнуудад тахал илүү хурц хэлбэртэй байсан. Хүйтэн уур амьсгалтай учир уушигны өвчинтэй хавсарсан байдлаар өвтгөж хүн амын талыг устгасан.



1350 оны өвөл

Greenland

Iceland

- Исландын хүн амын 50 хувь нас барж, Грийнландад сууришсан хүмүүсийн дийлэнхийг авч одсон.



- Европын хүн амын 50 хувийг устгасан гэж тооцдог.

Хар Үхэл


- Ойрх Дорнодод Александриа болон Каир хотуудыг нэрвэж Египетын хот суурин газрын хүн амын тал орчмыг устгасан (1347-1348).
- Дундад зуунд Хар тахал, Еврази болон Африк цаашилбал Хойд Америкт хүрсэн.
- 14-р зууны энэхүү гамшиг дэлхийн олон хэсэгт урт хугацааны үр дагавар үлдээсэн. Хүн ам аймшигтай байдлаар цөөрсний зэрэгцээ нийгэм, эдийн засгийг дахин бүтэцлэх шаардлага үүссэн.

Хар Үхэл

- Тахлын дараа Европыг цөхрүүлээд байсан өлсгөлөн, удаан үргэлжилсэн дайн тулаан, иргэний бослого, өвчлөл багасаж илүү тэсвэртэй эдийн засагтай болж ирсэн.
- Газар дээр ажиллах хөдөлмөрийн үнэ цэн нэмэгдэж аж ахуй эрхлэх үр чадвартай худалдаачдын нөлөө нэмэгдэж ирсэн.
- Craft Guild үүсгэн байгуулагдаж капиталист тогтолцооны үндэс суурийг тавьж худалдааг цэцэглүүлсэн.
- Хөдөлмөр хямд, газар үнэтэй байсан хуучин тэнцвэрт байдал хэдхэн жилийн дотор өөрчлөгдсөн.
- Хар Үхлээс өмнө Европын газар тариалангийн даац хэтэрсэн байсан. Технологийн дэвшил муу байсан учир илүү их газрыг ашиглахаас өөр арга байгаагүй.
- Үйлдвэрлэлийн гарц буурах нь хүн амын өсөлтөнд ихээхэн дарамт болж байсан. Харин тахлын дараа хөдөөний хүн ам цөөрсөн учир газрын эрэлт буурч, үнэ цэнээ алдсан (феодалын нийгэм халагдсан).



ЛЕКЦ ДУУСАВ.



14-р зууны сүүл үеийн нэгдэл ба монопол



Та энэ бүлгийг судалсанаар дараах чадваруудыг эзэмшинэ:

- Хар тахлын дараах үр дагаврыг тайлбарлах
- Үр тарианы үйлдвэрлэлээс махны үйлдвэрлэл рүү хийсэн шилжилтийг ойлгох, тайлбарлах
- Европ дахь феодалын нийгмийн задралыг тайлбарлах
- Хотын иргэншлийн талаар ойлголттой болох
- Европын түүхэн дэх иргэний зарим бослогуудыг тайлбарлах
- Хотын хөгжил ба худалдаа, усчуудын нэгдлүүдийн талаар тайлбарлах



Хар Үхэл

- Хар Үхэл тахлын улмаас Европт хүн амын тоо эрс багасаж өмнөх феодал эздийн зарц байсан тариачид өөрийн гэсэн газартай болсон.
- Шинэ газруудыг тариаланд ашиглахаас гадна шим тэжээл буурсан газруудыг орхиж явах болсон.
- Дараагийн зуунд хөрс, ой байгалийн жамаар ихээхэн сэргэсэн.
- Зүүн, баруун Европын цөөн хэдэн орныг тахлын аюул тойрч гарсан байв.



Хар Үхэл

Хүн ам эрс цөөрснөөр,

- Тариалангийн газрын ашиглалт буурсан.
- Үр тарианы үнэ буурсан.
- Ажилчдын тоо цөөрсөн тул цалин нэмэгдсэн.
- Газрын үнэ буурсан.
- Хөдөө аж ахуйн бус барааны үнэ буурсан.



Хар Үхэл

- Дундад зууны үеийн суурин хотуудын хүн ам, хөдөөний хүн амаас ихээр цөөрсөн.
- Жижиг суурингууд олноор устаж үгүй болсон бол томоохон хотууд хэмжээний хувьд улам томорсон.
- Ядуурал харьцангуй буурсан ч өлсгөлөнд нэрвэгдсэн тариачид олон байсан.



Хар Үхэл

- 15-р зуунд үр тарианы үнэ өсөж, буурч хэлбэлзэж байсан.
- Бяслаг, үхрийн мах өндөр үнэтэй хэвээр байсан.
- Хүн ам ихээр хорогдсон зарим газруудад хөдөө аж ахуйн ажилчны цалин 40-50 хувиар нэмэгдсэн. 15-р зууны турш нэмэгдсээр байсан.



Хар Үхэл

- Ажилчдыг хөлсөлж ажлуулах газрын эзэд түрээс, татвар, ажлын өндөр хөлс гэсэн тогтмол зардалтай байсан.
- Илүү ашиг олохын тулд илүү их тариалахаас өөр арга байгаагүй.
- Энэ цааш үр тарианы үнийг улам бууруулсан.



Хар Үхэл

- Тиймээс тариалан эрхэлдэг эзэд илүү ашиг олохоор үхрийн тэжээл, вино үйлдвэрлэл, хүнсний ногоо, мал аж ахуй, ялангуяа хонины ноос үйлдвэрлэх болсон.
- Хөдөө аж ахуйн барааны олон янз болсноор илүү шим тэжээлтэй хүнс хэрэглэх болсон.



- Үр тарианы үйлдвэрлэлээс махны үйлдвэрлэлд шилжсэн. Цааш Америк, Австрали тивүүдэд түгсэн.



- Хар Үхэл болон хүн амын хямралаас үүдэн нийгэм ихээхэн өөрчлөгдсөн ба боолуудын эрх, эрх чөлөө чухал болсон.
- Тариалангийн ажилчдын цалин нэмэгдсэн тул газрын эзэд газраа тэдэнд ихээр түрээслүүлэх болсон.
- Феодалын хамжлагат нийгмийг халах эхлэл болсон



➤ 18-р зууны баруун Европын Францын хувьсгал



➤ 19-р зууны Зүүн Европын хувьсгал



Хар Үхэл

- Феодал эзэд цалинг царцааж хамжлагат тариачдыг бага хөлсөөр ажиллуулахыг хичээдэг байсан ч хөдөлмөрийн хомсдолоос болж ажилчид илүү эрх мэдэлтэй болсон.
- Ажилчид түрээс, эрх чөлөөний илүү сайн нөхцлийг эздээс шаардах байр сууринд байв.



- Бага түрээс, илүү сайн нөхцөл, эрх чөлөөг олгохгүй бол бослого, үймээн ихээр дэгдэх болсон.
- 1358 онд Францын хойд хэсэгт тариачдын Jacquerie бослого гарсан. -



Хар Үхэл

- Шинэ тив, эх газрын нээлтүүд хийгдэхийн өмнөхөн Хар Үхэл нийгмийн өөрчлөлтийг эхлүүлж, хөдөө аж ахуй, мал аж ахуйн үйлдвэрлэлийг ихээхэн өөрчилсөн.
- Хот суурин газруудын хувьд Хар Үхэл тахал дэгдэхээс өмнө ариун цэвэр муу, бохирдол ихтэй, дайн үймээн, хүнсний хомсдол зэргээс болон нас баралтын хувь төрөлтын хувиас үргэлж дээгүүр байсан.



- Хар Үхэл тахлаас хойш хөдөө амьд үлдэгсэд илүү цалин хөлс, зах зээлийг хайж хот руу ихээр нүүн суурьших болсон.



Хар Үхэл

- Хөдөөний үйлдвэрлэгчид мал аж ахуйд ихээр шилжсэнээр хот суурин руу нүүх шилжилтийг улам нэмэгдүүлсэн.
- Газар тариалантай харьцуулахад мал аж ахуй хөдөлмөр бага шаарддаг.
- Хотод илүү ур чадвартай ажилчдын хэрэгцээ байдаг.



Хар Үхэл

- Тиймээс хот руу нүүн ирэх хүмүүс ихэвчлэн жижиг хот суурин газруудаас ирцгээж байв.
- Зарим хотуудад гаднаас шинээр ирэгсэдийн 30-аас илүү хувь гар урчуул байсан.
- Алс худалдаа хийдэг хотуудад ирэгсэдийн талаас илүү хувь худалдаачид, тээвэрлэгчид байсан.



Хар Үхэл

Улсын иргэншил,

- Сонгох, сонгогдох улс төрийн эрх
 - Төрийн хамгаалалтанд байх
 - Татварын хөнгөлөлт
-
- Тухайн үед хот суурин газрууд иргэншил олгодог байсан. Улс төрийн эрх, заримдаа худалдааг хязгаарласан эдийн засгийн давуу талыг иргэдэд олгодог байсан.



Хар Үхэл


- Хөдөөний хамжлагат ардууд хотын иргэн болоход бэрхшээлтэй байсан.
- Тахлаас хойш хагас зууны дараа хотын иргэд, шинээр нүүн ирэгсэд, байнгын оршин суугчид хотын нийгэмд томоохон, давамгайлах шинжтэй нийгэмлэгүүд болж ирсэн.
- Эдгээр нийгэмлэгүүдийн хооронд өрсөлдөөн, маргаан ихээхэн гарах болсон.



- 14-15-р зуунд Англи, Францын 100 жилийн дайныг санхүүжүүлэхээр Францын хааны гаргасан татварыг эсэргүүцсэн бослого гарсан.
- Хамгийн алдартай бослого 1378 онд Италийн Флоренц хотонд болсон Ciompi бослого байсан.
- Даавууны үйлдвэрийн ажилчид өөрсдийн цалин нэмэхийг шаардаж, мөн тэдний улс төрийн оролцоог нэмэгдүүлж өгөхийг шаардсан бослого байсан.




Хар Үхэл

- Доод ажилчдын нэгдэл бий болгох, өртэй хүмүүсийг баривчлахыг зогсоох, хүчээр зээл өгөхийг болиулах, үр тарианы үнийг бууруулах, даавууны үйлдвэрлэлийн хэмжээг тэнцвэржүүлэх квот тогтоож өгөхийг шаардсан.
 - Бослого хэсэгчлэн амжилтанд хүрсэн.
- 



Хар Үхэл

- 
- Европын хотуудад олон тооны бослогууд гарсан ба хотын удирдлагын шийдвэр гаргалтанд нэгдлүүдийг оролцуулахыг шаардсан тайван жагсаал цуглаан дийлэнх байжээ.
 - Гэвч ядуу ажилчдын нэгдэл зохион байгуулалт муутай байсан тул төдийлөн амжилтанд хүрэхгүй, язгууртан, худалдаачин, баячуудын нэгдэл шийдвэр гаргалтанд ихээр оролцох болсон.



Хар Үхэл

- Бослогын бодит үр өжөөжийг хотын элитүүд хүртэж Европ даяар цалин нэмэгдэж буй нөхцөл байдалд хамгийн эрэлттэй олон төрлийн бараануудыг үйлдвэрлэх, худалдаалах болсон.
- 14-р зууны эдийн засгийн бодлого өөрийн хотын бараа, бүтээгдэхүүнийг бусад хотын өрсөлдөөнөөс хамгаалахад чиглэж байсан.



Хар Үхэл

- Ихэвчлэн язгууртнуудыг хамгаалсан эдийн засгийн бодлогууд монопол, онцгой эрхтэй, гадны худалдаачдыг эсэргүүцсэн шинжтэй байсан.
- Хар Үхэл тахлаас хойш үүссэн дүрэм журам хэт нарийн, тодорхой, protectionist агуулгатай байжээ.



Хар Үхэл

- Европын томоохон худалдааны хотууд,
 - London and Bristol, England
 - Florence and Venice, Italy
 - Ghent and Bruges, Flanders
 - Paris, France
 - Cologne and Nuremberg, Germany



Хар Үхэл

- Томоохон хотууд өөрийн байр суурийг бататгаж ихээхэн эдийн засгийн хувьд бэхжиж ирсэн.
- Жижит хотууд Монопол бодлого хэрэгжүүлж өөрсдийн байр суурийг бий болгох хичээх болсон.
- Хотын зөвлөлүүд нэгдэл болон худалдаачдад монопол эрх олгосон. Бүсийн лордууд хотуудад монопол эрх, хааны засгийн газраас илүү их газар нутаг хамарсан бүс нутагт хураамж авах, худалдаа эрхлэх зэрэгт монопол эрх олгосон.



Хар Үхэл

- 14-р зуунд гар урчуудын нэгдэл тодорхой барааг үйлдвэрлэх монопол эрх авч байсан.
- Нэгдэлд элсэхийг хязгаарлах, чанарын хяналт бий болгох, материалын стандарт, доод үнийг тогтоох зэрэг арга хэмжээ авч байсан.
- Тодорхой барааг худалдаалах тусгай газруудыг бий болгосон. Ghent – үр тариа, Calle – хонины ноос – татварыг хураахад тустай



Хар Үхэл

- Дотоодын аж үйлдвэрийг хамгаалах зорилготой монополууд ихээр үүссэн.
- English wool company – хамтарч үнийг өсгөсөн.
- Тухайн хотын ашиг сонирхолд хамгийн их нийцсэн нэгдлүүдийг дэмжиж монопол үүсгэж байсан.




Хар Үхэл

- Монопол нь хамгаалах бодлого учир хотуудын хооронд мөргөлдөөн үүсэх болсон.
- Томоохон хотууд эдийн засгийн хувьд төдийлөн бие даасан байгаагүй.
- Хотууд боломжит хамгийн их үйлдвэрлэл, орлого, худалдааг дотооддоо явуулах эдийн засгийн бодлогыг хэрэгжүүлж байсан.



Хар Үхэл

- Дундад зууны сүүлээр Европын хотуудад гадны худалдаачдыг хязгаарлаж тэдний тоо хэмжээг хатуу чанд тогтоодог байсан.
- Энэхүү protectionist бодлого Европын бараг бүх хотод хэрэгжиж байсан.
- Гадны худалдаачид аливаа жижиглэнгийн худалдаа хийх хориотой. Мөн бусад гадны худалдаачинтай наймаа хийхийг зөвшөөрдөггүй байсан.



- Хотууд эрх мэдлээ ашиглан гадны худалдаачдаас татвар ихээр авч өөрийн иргэдээс татвар авдаггүй байсан.
- Хотод нэвтрэхэд гадны худалдаачдыг бүртгэж хураамж авч оруулдаг байсан.



Хар Үхэл

- Бүх хотууд хэт хамгаалсан бодлого явуулснаар тэдний гадаад худалдаа зогсонги байдалд орж эхэлсэн ба өөрийн худалдаачдыг дэмжихийн тулд дүрэм, журмыг сулруулахаас өөр аргагүй болсон.
- Тиймээс гадаад худалдааны гэрээг харилцан хийж, харилцан худалдааны давуу талыг тохиролцох болжээ.

Хар Үхэл

- Зарим хотууд илүү чөлөөт худалдааны бодлогыг эрхэмлэж ашиг тусыг хүртэж байсан.
- Antwerp хот чөлөөт худалдааны бодлого хэрэгжүүлж гадны худалдаачдыг ихээр дэмжсэн.
- Европын томоохон хотууд жижиг хотуудын худалдааны инновацийг үл хайхран хөгжлөөс хоцорч эхэлсэн.
- Antwerp хотын чөлөөт худалдааны бодлого дараагийн хэдэн зуунд Европыг хөгжүүлэх нөхцөл болсон.
- Хар Үхэл тахлын дараа хэдэн арван жил Европын нийгэм, эдийн засаг хувьсан өөрчлөгдсөн. Дундад зууны монопол, хэт тусгаарлалт, хэт давуу талыг баримтлагч үзлүүд арилж эхэлсэн.
- Гадаад ертөнц рүү чиглэсэн чөлөөт худалдаа, эрх чөлөөний үзэл баримтлал давамгайлж эхэлсэн.



ЛЕКЦ ДУУСАВ.